

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ**

2016 оны 11 дугаар  
сарын 15 -ны өдөр

Дугаар A/23, A/130

Улаанбаатар хот

**Зааварт өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын “Дүрэм шинэчлэн батлах тухай” 2015 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Заавар шинэчлэн батлах тухай” А/85/241 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Иргэн /даатгуулагч/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоох, хөдөлмөр зохицуулалт хийх заавар”-ын 6.5 дахь хэсгийг дор дурдснаар өөрчлөн найруулсугай.

1.1.“6.5.Шүүхээр ял эдэлж буй ялтны ХЧА-ыг шинээр тогтоохгүй ба зөвхөн урьд тогтоолгосон ХЧА-ын хувь, хугацааг сунгах эсэх асуудлыг тухайн хорих байгууллагын харьяа аймаг (дүүрэг)-ийн ЭХМК шийдвэрлэнэ.”

2. Энэ тушаалаар баталсан зааврын өөрчлөлтийг мөрдөж ажиллахыг Нийгмийн даатгалын байгууллагын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, эмнэлгийн байгууллагуудын Эмнэлэг хяналтын комисст тус тус үүрэг болгосугай.

3. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоох үйл ажиллагаанд мөрдөх зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т тус тус даалгасугай.

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД**

Н.НОМТОЙБАЯР

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД**

А.ЦОГЦЭЦЭГ